

Хотолборийн хоёр дахь үндсэн зорилтын хүрээнд малчид зохион байгуулалтанд орсноор бие даасан байдлаа бэхжүүлж, байгалийн нооц баялаг ашиглах, тулгарч буй бэрхшээлийг даван туулахад хамтран ажиллах, байгаа нооц бололцоондоо тулгуурлан мал аж ахуйн бус орлогоо нэмэгдүүлж амьдралаа дээшлүүлэх, харилцан туршлагаа солилцох зэрэгт нь тэднийг дэмжин ажиллаж байна. Энэ үйл ажиллагааг:

1. Архангай аймгийн Их Тамир,
2. Баян-Олгий аймгийн Цэнгэл,
3. Дундговь аймгийн Олзийт,
4. Завхан аймгийн Тэлмэн,
5. Тов аймгийн Ондорширээт сумдад хэрэгжүүлж байгаа юм.

Одоогоор дээрх 5 суманд Бэлчээрийн Хамтын Менежментийн Хороо ТББ байгуулагдан, орон нутагтаа бэлчээрийн хамтын менежментийн ажлыг зохион байгуулах, толовлогооний хэрэгжилтийг хангах, "Малчдын Сургалт Мэдээллийн Тов"-оор дамжуулан малчдад мэдлэг мэдээлэл түгээх, идэвхижүүлэх, ололт амжилтыг түгээх ажлыг хийж байна.

Бэлчээрийн хамтын менежментийг хэрэгжүүлснээр малчдад ямар үр ашиг авчирч болохыг "Ногоон Алт" хотолборийн хүрээнд хэрэгжсэн олон ажлууд харуулж байна. Баян-Олгий аймгийн Цэнгэл суманд 2005-2006 онд малчид хүч ходолмороо нэгтгэн ходолморлож, чулуун хашаа барин 1060 га нооц бэлчээр хамгаалсан нь байгаль цаг уурын хүнд ноцолд эрсдэлд орохоос хамгааллаа.

Мон Архангай аймгийн Их Тамир болон бусад сумдад зохион байгуулсан сарлагийн хоовор самнах, боловсруулах сайжруулсан технологийн сургалт нь малчдад орлогоо нэмэгдүүлэх ихээхэн боломж олгосон ажил болсон юм.

Тов аймгийн Ондорширээт суманд "Буриад гутал хийх" сургалтыг "Амьдрах ухаан" товтэй хамтран зохион байгуулсны үр дүнд сургалтанд оролцогсод буриад монгол гутал, голом дэвсийг дизайны овормоц шийдэлтэй хамгийн орчин үеийн моод стильд нийцсэн, материалын сонголт сайтай, зохион бүтээлтийн

хялбар аргачлалаар, технологийн ондор твшинд, зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хийж сурлаа. Цаашид ТББ-ын дэргэд жижиг цех байгуулан ажиллах боломжийг судалж байгаа богоод дараагийн шатны сургалтыг зохион байгуулах хвсэлтийг сургалтанд оролцогчдоос хвлээн аваад байна.

Малчдад оорсдийн боломж нохцолоо ашиглаад орлогоо нэмэгдүүлэх боломжийг нээж огох, мэдлэг мэдээлэл огох хэрэгцээ шаардлага ондор байна. Дээрх сургалтуудаас гадна хотолбор хэрэгжиж буй сумдын малчид хвсэлт гаргасны дагуу жимсний чанамал хийх, эсгий эдлэл хийх, хвнсний ногоо тариалах, даршлах, ногоон тэжээл бэлтгэх, даршлах зэрэг сургалт зохион байгуулсан. Цаашид ч дээрх сургалтуудыг үргэлжлүүлэн зохион байгуулах богоод идэвхи санаачлагатай малчид, сум орон нутгийг дэмжин вйл ажиллагаагаа аль болох оргон хврээнд хвргэж, аль болох олон малчдад амьдралаа дээшлүүлэхэд нь туслахыг зорьж байна.

Малын тооноос илvv чанарт анхаарах цаг болсныг малчид аль хэдийн ойлгож эхэлжээ. Олон чанаргвй мал бэлчээр их талхлахаас гадна үр шим муутай, цаг уурын хвнд хэцvv нохцлийг дааж гарах чадвар муутай байдаг учраас малын вүлдэр угсааг сайжруулан, гарах ашиг шимийг нь нэмэгдүүлэхэд анхаардаг болсон байна. "Ногоон Алт" хотолбор ч вүнийг дэмжиж "Монгол сарлаг" нийгэмлэгтэй хамтран ажиллаж байна.